



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 2/80

Тавин

2023-2024 оны Өвөлжилт, Хаваржилтын
бэлтгэл хангах төлөвлөгөө боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.11, 27.5.12, 27.5.14, 27.5.16 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 279 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны А/459 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. “Хөдөө аж ахуйн салбар болон төв суурин газрын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах зарим арга хэмжээний тухай” Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 02 тоот албан даалгавар, 2023-2024 оны Аймгийн Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын явцад хяналт тавих, хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2. Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024-оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны 10 сарын 10-ны дотор хангаж, тайлан мэдээг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст 2023 оны 10 сарын 20-ны дотор хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ч.Оюунцэцэг), (О.Ганбаатар) нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын тогтоол, Аймгийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийг 2023 оны 09 дугаар сарын 25-ны дотор зохион байгуулж, дүн мэдээг 10

сарын 25-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Ч.Оюунцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ